

## ШУУРХАЙ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 4 дүгээр сарын 29

№ 12

Дархан-Уул аймаг

Аймгийн Засаг даргын Шуурхай хурал 2019 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 08 цаг 30 минутад аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд хуралдав. Хуралдааныг аймгийн Засаг дарга С.Насанбат удирдаж, хуралд нийт 18 удирдах албан тушаалтнууд оролцохоос 15 оролцож хуралдааны ирц 83.3 хувьтай байв. Гишүүдийн ирцийн бүртгэлийг хавсаргав.

### **ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:**

1.Хэлтэс, алба, сумдын дарга нарын өнгөрсөн 7 хоногийн ажлын тайлан, холбогдох шуурхай мэдээ, мэдээллийг танилцуулах, өмнөх шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаарх мэдээ, тайланг танилцуулах.

Хуралд оролцсон хэлтэс, албад, сумдын дарга нар өнгөрсөн 7 хоногт хийсэн ажлын тайланг танилцуулав.

### **ҮҮРЭГ ДААЛГАВАР:**

Аймгийн ИТХ-ын ээлжит 13 дугаар хуралдаанаар 2019 оны орон нутгийн төсөвт тодотгол хийх тухай асуудлыг хэлэлцэх тул хуралдааны бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах

2019 оны орон нутгийн төсвийн тодотголыг аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхийн өмнө УИХ-ын гишүүдийн саналыг авах

Төсвийн тодотголын өмнө төсвийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой буцаалт хийнэ. (176 сая төгрөг)

Их, дээд сургууль, Ерөнхий боловсролын сургуулийн төгсөлтийн үйл ажиллагаатай холбоотой Захирамж, Тушаал боловсруулах хэрэгтэй.

2019 оны хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор тендер, сонгон шалгаруулалтын ажлыг эрчимжүүлэх

“Дархан хот байгуулалт Барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар болон Мэргэжлийн хяналтын газартай ажлын уялдаа холбоог хангаж ажиллах

Цахим тендерээр шалгарч буй байгууллагыг хурдан ажилд нь оруулах

Хаврын мод тарих ажлыг эрчимжүүлж иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах

Хаврын хуурайшилттай холбоотойгоор хотын ногоон байгууламжийн усалгааг чанартай хийж гүйцэтгэх, хяналт тавих

Сумдын Засаг дарга нар сумандаа тогтвор суурьшилтай ажиллах

Агентлагийн дарга нар ажлын байрандаа тогтвор суурьшилтай ажиллах, үйл ажиллагаанд хяналт тавих

Зарим агентлагийн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээг 2019 оны 05 дугаар сард аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх ажлыг аймгийн ЗДТГ-ын дарга Ч.Энхбат судлах

Морин эргүүлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх. Уул уурхайн компаниуд ажлаа эхлүүлж байна.

Орхон сумын ИТХ-ын даргыг Засаг дарга Б.Алтансарнай 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр аймгийн Засаг даргатай уулзуулах

Иргэдийн үнээг (100 үнээ) хээлтүүлэх ажил ямар шатанд явж буй тухай мэдээллийг өгөх хэрэгтэй байна. Гэрээ хийгдсэн. Уг ажилд Малын удмын сантай хамтарч ажиллах асуудлаар тодруулга өгөх

Орхон сумын ИТХ дахь МАН-ын бүлэгтэй аймгийн Засаг даргын орлогч Т.Ганболд уулзаж төлөвлөгдсөн ажлуудыг эрчимжүүлэх

Хонгор сумын уринштай талбайг түрээслэх асуудлыг ямар хэлбэрээр явуулах тухай мэдээллийг өгөх

Багийн төвийн барилга, Төрөх эмнэлгийг ашиглалтад оруулах ажлыг эрчимжүүлэх

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс болон Орон нутгийн өмчийн газар “Дархан хот байгуулалт, Барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын дарга Н.Батсайханы ажлыг эрчимжүүлэхэд анхаарч ажиллах

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс болон Орон нутгийн өмчийн газар “Дархан хот байгуулалт, Барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын дарга Н.Батсайханы ажлыг эрчимжүүлэхэд анхаарч ажиллах

Захирагчийн алба Дархан сумын нутаг дэвсгэрт байгаа зөвшөөрөлгүй хашааг буулгах ажлыг эрчимжүүлэх

Агентлагийн дарга нарын ажлын цаг ашиглалтад хяналт тавьж анхаарч ажиллах

Агентлагийн дарга нарын томилолтыг ЗДТГ-ын дарга урьдчилан хянасан тохиолдолд Засаг дарга гарын үсэг зурна. Иймд агентлагийн дарга нар гадаад, дотоод томилолтын тайланг Засаг даргад тогтмол ирүүлж байх

Хурал 9 цаг 55 минутад дуусав

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС